

## Физикийн тэнхимийн үйл ажиллагааны хураангуй

2018 оны 06-р сарын 20-23

### 2nd "Belt and Road" Forum on International Exchange of Science and Technology 7th International Conference on Materials Science (ICMS2018) 2nd Joint Chinese-Mongolian-Russian International Conference on Functional Materials 20-23 June 2018 | Erenhot, China

Монгол Улс, БНХАУ, ОХУ-ийн хамтран зохион байгуулдаг Материал судлалын олон улсын хурлын 2018 оны ээлжит хурлыг БНХАУ-ийн Эрээн хотноо Өвөр Монголын багшын их сургууль 2018 оны 8-р сарын 20-аас 23-ны хооронд амжилтай зохион байгууллаа.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурал нь материал судлалын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаачидын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага судлах, мэдээлэл солилцох, судалгааны ажлын шинэлэг үр дүнгүүдээ танилцуулах зорилготой билээ. Энэхүү зорилго амжилттай биелэж байгааг нэгэн тод жишээ нь энэхүү хурал болж байгааг дурдахад таатай байна. Тус хуралд Монгол, БНХАУ, ОХУ, Герман, Франц, Беларус, Голланд, Солонгос зэрэг 10 гаран улсын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын 100 –аад эрдэмтэн судлаачид оролцож 23 нь аман илтгэл, 58 ханын илтгэл хэлэлцүүлэв.

Энэхүү хурлыг монголын талаас Монголын физикийн нийгэмлэг, МУИС, ШУА-ийн ФТХ, ХХТХ болон Тээврийн дээд сургуулаас нийт 30 гаруй хүний бүрэлдэхүүтэй баг оролцоод ирлээ. МУИС-ийн хувьд тус хуралд нийт 11 илтгэл хэлэлцүүлэв.



2018 оны 8-р сарын 16-19

### BIRDS олон улсын төслийн 3 дугаар хурал, Монголын байгаль орчинд хиймэл дагуулын мэдээлэл ашиглалт олон улсын 8 дугаар хурал

Монгол Улсын Их Сургууль сансрын инженерчлэлийн боловсон хүчин бэлтгэх, хэрэглээний шинэ арга замуудыг судлах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой BIRDS олон улсын төслийн 3 дугаар хурал, “Монголын байгаль орчинд хиймэл дагуулын мэдээлэл ашиглалт олон улсын 8 дугаар хурал”-ыг 2018 оны 8 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд зохион байгуулж байна. Хурлын нээлтэд МУИС-ийн захирал Я.Төмөрбаатар, Монгол Улсын анхны сансрын нисгэгч, МУ-ын баатар Ж.Гүррагчаа нар үг хэлсэн бол МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн мэндчилгээ, илгээлтийг генерал Ц.Тогоо, БСШС-ын сайдын мэндчилгээг С.Мөнхбат уламжилав.



Хурлын нээлтийн үйл ажиллагааны үеэр МУИС-ийн төслийн багаас МУИС-ийн захирал Я.Төмөрбаатарт хиймэл дагуул амжилттай хөөргөсний 001 дугаарт батламж болон JAXA-аас ирүүлсэн МАЗААЛАЙ-ийн REMOVE BEFORE FLIGHT PIN (Олон Улсын Сансрын Станцаас буцааж авчирсан хиймэл дагуулын түлхүүр)-ийг хүлээлгэн өгөв. Хуралд гадаадын 18 улсын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөгчид, мөн тооны дотоодын судлаачид хүрэлцэн ирж нийт 44 илтгэл тавигдлаа. Монгол Улсын Их Сургууль нь хөгжиж буй орнуудын сансрын технологийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх зорилготой олон улсын BIRDS төслийн хүрээнд Монгол Улсын анхны сансрын хиймэл дагуул “Мазаалай”-г 2017 оны 7 дугаар сард сансарт хөөргөсөн билээ. Одоогоор “Мазаалай” хиймэл дагуул хамт хөөрсөн хиймэл дагуулуудаас ганцаараа ажиллаж, мэдээлэл дамжуулж байгаа юм.

**2018 оны 10-р сарын 13**

### **Тогтвортой хөгжил – Физикийн салбар**

Хаана: МУИС-ийн харъяа Төв аймаг дахь “Өвөр Зайсан” судалгааны бааз  
 Сургалтанд оролцогчид: МУИС, Физикийн тэнхимийн багш, ажилтан  
 Сургалтын зорилго: ТХБ-Даяар Үйлийн Хөтөлбөрийн зорилго зорилтуудыг Физикийн салбарын хөтөлбөрийн хичээлд тусгасан байдал, хэрэгжүүлэх боломж туршлага солилцох.  
 Сэдэв: Хичээлийн агуулгадаа ТХ-ийн ямар агуулгыг тусгах, сургалтын орчин бүрдүүлэхэд анхаарах зүйлс, боломж бэрхшээл, дүгнэлт тайлбар.





2018 оны 11-р сарын 2-3

### Физик, Физик боловсролын асуудал эрдэм шинжилгээний хурал

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарын Физикийн тэнхим нь “ФИЗИК, ФИЗИК БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ” Үндэсний эрдэм шинжилгээний хурлыг Монголын Физикийн Нийгэмлэг, ШУА-ийн Физик, Технологийн Хүрээлэн, ШУТИС, МУБИС зэрэг сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн. Энэ удаагийн ээлжит хурлыг **ШУА-ийн жинхэнэ гишүүн, Монгол улсын гавьяат багш, доктор, профессор Н.Содномын мэндэлсний 95 жилийн ойд зориулан** 2018 оны 11-р сарын 02-03-ны өдрүүдэд МУИС-ийн Номын сангийн 502 тоот хурлын тэнхимд амжилттай зохион байгууллаа. Энэхүү хурлын зорилго нь физикчдэд эрдэм шинжилгээ, судалгааны сүүлийн үеийн үр дүнгээ танилцуулах боломжийг олгох, шинэ санаа бодлоо харилцан солилцох, ахмад үеийн амжилт бүтээлийг алдаршуулах, цаашдын хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэхэд чиглэгддэг. Монгол улсын хэмжээнд ажиллаж байгаа бусад эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн багш, эрдэм шинжилгээний ажилтнуудын хамтын ажиллагааг эрчимжүүлснээр илүү их ололт ажилтанд хүрэх боломжтой. Энэ удаагийн ээлжит эрдэм шинжилгээний хуралд МУИС, ШУТИС, МУБИС, ШУА-ийн ФТХ-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтан судлаачийн шинэлэг санаа дэвшүүлсэн нийт 21 аман илтгэл, 8 ханийн илтгэл, нийт 29 илтгэл хэлэлцүүлсэн бөгөөд 100 гаруй их дээд сургуулийн эрдэм багш, эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдийн эрдэмтэн судлаачид, ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон их дээд сургуулийн судлаач оюутнууд оролцов.



Тус хуралд урилгаар ОХУ-ийн ШУА-ийн Сибирийн салбарын Физик-Материал судлалын институтын захирал профессор А.В.Номоев “Композитные наночастицы: создание, структура, свойства и применения” сэдэвт илтгэл, БНХАУ-ийн Өвөр Монголын багшийн их сургуулийн Функционал материалын физик химийн төв лабораторийн эрхлэгч Профессор О.Төгс “Research and developments in superconductivity” сэдэвт илтгэлүүд хэлэлцүүлэв.

Энэхүү хурлын үеэр Монголын физикийн нийгэмлэгийн зүгээс олгодог хурлын шилдэг илтгэлийг шагналаар МУИС-ийн Физикийн тэнхимийн лаборант Э.Номин-Эрдэнийн “Measurement of the  $tt\gamma$  production cross-section in  $pp$  collisions at a center-of-mass-energy of  $\sqrt{s} = 13$  TeV with the ATLAS detector at the LHC” сэдэвт илтгэл шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдав. Тус хуралд хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдийн МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг 495, ФИЗИК (27) / ISSN Print-2311-1097/ сэтгүүлд эмхтгэн гаргасан болно.

2018 оны 10-р сарын 13

2018 оны 10-р сарын 25-наас 2019 оны 05 сарын 03 хүртэл Азийн физикийн олимпиадын бэлтгэлийг МУИС-ийн физикийн тэнхимийн ахлах багш Д-р. Г.Мөнхбаяр, М.Отгонбаатар нар хийж Азийн физикийн 20-р олимпиадад амжилттай оролцсон.

2018 оны 11-р сарын 07

**“АСТРОНОМИЙН ОЛОН УЛСЫН ХОЛБОО – 100 ЖИЛ” тусгай  
үйл ажиллагаа зохион байгуулагдлаа**

Астрономийн Олон улсын Холбоо (АОУХ)-ны 100 жилийн ой 2019 онд тохионо. Түүхийн энэхүү онцлох ойг тэмдэглэхэд Астрономийн Олон улсын Холбоо нь “Нэг тэнгэрийн дор” сэдэвт шинжлэх ухааны боловсролд зориулсан астрономийн хөгжлийг сайжруулах, дэмжих, мөн сүүлийн 100 жилийн астрономийн нээлтүүдийг сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх жилийг санаачилсан байна. Манай улс энэ ажлын хүрээнд Астрономийн Олон улсын Холбооны 100 жилийн ойг угтаж зорилтот үйл ажиллагаа зохион байгуулсан.

- Астрономийн шинжлэх ухааны гэж юу вэ?
- Монголчуудын астрономийн боловсрол хэдийгээс уламжлагдаж ирсэн
- 100 жилийн үйл ажиллагааг тэмдэглэх учир гэх мэт хэлэлцүүлэг болж өндөрлөлөө.

Энэхүү үйл ажиллагаанд эрүүл мэнд, батлан хамгаалах, хүмүүнлэг, соёл урлаг, байгалийн ухаан, электроник, антропологи, социологийн салбарынхан болон Монголын үүрэн харилцаа холбооны байгууллагуудаас төлөөлөл оролцлоо.

Та бүхэн Астрономийн олон улсын холбооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкээр холбогдон авах боломжтой.

<https://www.iau.org/> – АОУХ-ны вебсайт

<https://www.iau-100.org/> – АОУХ-ны 100 жилийн ойн вебсайт



2018 оны 12-р сарын 6

**Монгол улсын гавьяат багш Ц.Ханд агсаны  
нэрэмжит физикийн олимпиад**

“Монголын физикийн боловсролыг дэмжих сан” ТББ, Улсын физикийн олимпиадын хороотой хамтран жил бүр Монгол улсын гавьяат багш Ц.Хандын нэрэмжит “Физик инженерчлэлийн олимпиад”-ыг зохион байгуулдаг уламжлалтай. Энэ удаагийн XIX бага олимпиадыг Ц.Хандын нэрэмжит сан, “Жи мобайл” ХХК, Ц.Ханд багшийн шавь Мөнхбат Баттулга нар хамтран ивээн тэтгэсэн байна. Тус олимпиадад нийслэл болон хөдөө орон нутгаас 6-12 дугаар ангийн нийт 565 сурагч оролцсон юм. Тухайлбал,

- 6-р ангид 131 сурагч
- 7-р ангид 157 сурагч
- 8-р ангид 118 сурагч
- 9-р ангид 76 сурагч
- 10-р ангид 76 сурагч
- 11-р ангид 52 сурагч
- 12-р ангид 39 сурагч тус тус хоорондоо өрсөлдөж, нийт 649 сурагч мэдлэг чадвараа сорьсон байна.

Мөн 12 ангийн төрөлд алт авсан сурагч Д.Хонгор “Жи Мобайл” ХХК-ийн зүгээс их сургуулиа төгсөөд хамтран ажиллах урилга өгсөн юм.

Онооны дүнгээр

- 1,2,3,4-р байранд медаль, өргөмжлөл, шагнал /тэргүүн байр мөнгөн шагнал/
- 5,6 байранд талархал, шагналын хамт тус тус гардууллаа.

Багийн нийлбэр оноогоор Ерөнхий боловсролын “Сант” сургууль нэгдүгээр байранд орж, хоёрдугаар байранд 11-р сургууль, гуравдугаар байранд орчлон сургууль тус тус оржээ.



**2018 оны 12-р сарын 9**

МУИС-ийн Багш мэргэжлийн оюутнуудын дунд зохион байгуулдаг “Багшлахуйн ур чадварын тэмцээн-2018”-д Физикийн Багш мэргэжлийн 3-р ангийн 5 оюутан нэг баг болон илтгэл тавьсан. Физикийн Багш мэргэжлийн 3-р ангийн Б.Баттуяа, Б.Мандах-Оргил, Б.Уянга, С.Даринчулуун, Д.Энхсайхан нарын баг гутгаар байр эзэлсэн.

**2018 оны 12-р сарын 31**

### **Алтангадас одонгоор шагнууллаа**

Тулгар төрийн 2227 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 812 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 107 жил, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Ардчилсан хувьсгалын 29 жилийн ойг тус тус тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга зарлиг гаргаж МУИС-ийн зарим багш, ажилтнуудыг төрийн дээд одон, медалиар шагнасныг шинэ оны отгон өдөр МУИС-ийн захирал, доктор Я.Төмөрбаатар гардууллаа. Төрийн дээд Алтангадас одонгоор МУИС-ийн ШУС-ийн Физикийн тэнхимийн дэд профессор Ж.Ванчинхүү шагнууллаа.





2019 оны 1-р сарын 07-28

### Англи хэлний сургалт зохион байгууллаа

Тэнхимийн багш, ажилтныг дэмжих үйл ажиллагааны хүрээнд гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх зорилгоор С.Мөнхцэцэг багш тэнхимийн залуу багш, туслах ажилтан нарт Англи хэлний хичээл 1 сарын хугацаанд орлоо.

2019 оны 1-р сарын 8

### Ардиуно бичил робот хөгжүүлэх сургалт

Уламжлал болгон зохион байгуулдаг Ардиуно бичил робот хөгжүүлэх сургалт нь физик болон электроникийг анхнаас суралцан эхэлж буй сонирхогчид, оюутан, сурагчид болон анхлан суралцагчдад зориулсан Arduino хавтан дээрх ардиуно бичил робот хөгжүүлэх бөгөөд сургалтад оролцогчдыг бүх шаардлагатай материал, сургалтын хавтангаар хангах өөрт нь үлдээх зорилготойгоор 3 долоо хоногийн хугацаагаар Д-р. Д.Эрдэнэбаатар багш болон М.Алтансүх нар сургалтыг удирдан явуулсан.



2019 оны 2-р сарын 10-наас 5-р сарын 1

### Найрал дууны нэгдэл

Г.Мөнхбаяр, С.Мөнхцэцэг, Ш.Мөнхжаргал багш нарын санаачилсан МУИС -ийн багш ажилтны "Найрал дууны нэгдэл" төслийг бичиж, хичээлийг эхлүүлсэн.

Найрал дуу нь тухайн хүнийг заавал мундаг "тенор" хоолойтой байхыг шаарддаггүй бөгөөд стресс тайлах, олон найз нөхөдтэй болох зэрэг олон сайн талтай юм байна.



2019 оны 2-р сарын 13

### 2-р түвшний оюутнуудын уулзалт

Физик болон Багш, байгалийн ухааны боловсрол (Физик) хөтөлбөрийн 2-р түвшний оюутнуудтай уулзаж тэнхимийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөр, хичээл сонголт,

тэтгэлэг урамшуулал, давтлагын талаар мэргэжлийн зөвлөгөө өглөө. Мөн тус оюутнууд судалгааны лабораториудтай танилцлаа.



**2019 оны 2-р сарын 15**

### **“ДИДАКТИКИЙН ШИЙДЭЛ БҮХИЙ ФИЗИКИЙН ДИЖИТАЛ КОНТЕНТ” төсөл**

Ус төслийг 2019.02.15-2020.01.15 хугацаанд хийж гүйцэтгэнэ. Физик Математикийн мэдлэгийг богино хугацаанд, орон зай, цаг хугацаанаас хамаарахгүйгээр, онол практик хосолсон аргаар системтэйгээр эзэмшүүлэх нь манай төслийн бүтээгдэхүүний гол үнэ цэнэ юм. Төслийн уулзалт 14 хоногт нэг удаа уулзаж ажлаа тайлагнаж байна.

Төслийн удирдагч: МУИС, ШУС, БУС Физикийн тэнхим, Д-р. Дэд Проф. Д.Улам-Оргих

**2019 оны 2-р сарын 26**

### **Физикийн тэнхимийн хөтөлбөрийн хорооны хурал**

Комиссын дарга: Д.Улам-Оргих/Тэнхимийн эрхлэгч, дэд проф/

Гишүүд: Ж.Даваасамбуу / профессор/

Ж.Вөнчинхүү /дэд проф /

П.Мөнхбаатар /багш/

Ж.Дөлгөөн /багш/

Комисс 1-р байрны 311 тоотод 15:00 цагаас эхэлж 17:15 дуусав.

1. Физик хөтөлбөрийн одоогийн уяалдаа холбоог өөрчлөх
2. Физик ба Физикийн багшийн хөтөлбөрийн агуулга хэрхэн сайжруулах вэ?
3. Шинэ хөтөлбөр нээх асуудал хэлэлцсэн.

**2019 оны 2-р сарын 18**

### **Оюутнуудад давтлага, сургалт, семинар**

Физик, Физикийн багш хөтөлбөрийн 2 болон 3-р ангийн оюутнуудад 7 хоног бүрийн Даваа гариг 12:40-өөс Боорцогтой семинар, давтлага, сургалт Д.Улам-Оргих, Д.Эрдэнэбаатар багш нар орж эхэллээ.





**2019 оны 3-р сарын 7**

### **Оюутнуудын хамтарсан семинар**

Физик болон Багш, байгалийн ухааны боловсрол (Физик) хөтөлбөрийн 2, 3-р түвшний оюутнууд, магистрант, докторант суралцагчдын хамтарсан семинар болж өнгөрлөө.



**2019 оны 3-р сарын 20**

### **Сансар огторгуйн нээлт сүүлийн зуун жилд**

Астрономийн Олон Улсын Холбоо (International Astronomical Union – IAU) байгуулагдсан 100 жилийн ой 2019 онд тохиож байна. Энэхүү түүхийн онцлох хугацааг тэмдэглэхийн тулд Дэлхийн олон улс өөр өөрсдийн арга хэмжээг зохион байгуулж эхлээд байна. Монгол улсыг төлөөлөн энэхүү арга хэмжээг 2019 оны 3-р сарын 20-ны өдрийн 18 цагт зохион байгуулсан.

Илтгэгч: Профессор Н.Түгжсүрэн



Сэдэв: Монголчуудын уламжлалт астрономийн мэдлэг  
Илтгэгч: Профессор М.Отгон  
Сэдэв: Хүний хөгжил ба скалар долгион  
Зохион байгуулагч: МУИС-ийн Физикийн тэнхим

Лекцийн зорилго нь сүүлийн 100 жилийн шинжлэх ухааны нээлтүүдийг таниулах, дэмжих, соён гэгээрүүлэх юм.



Дурангаар од, сар ажиглалт: Номын сангийн байр, Сансар судлалын лаборатори 616 тоот, 20:30 цагт

**2019 оны 4-р сарын 13**

### **МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ**

Мэргэжлийн хөтөлбөр сурталчлах өдөрлөг зохион байгуулагдлаа. “Физик”, “Багш, байгалийн ухааны боловсрол (Физик) “-ын бакалаврын хөтөлбөрүүдийг сурталчлах өдөрлөгт амжилттай зохион байгуулагдлаа.



Тус өдөрлөг 2019 оны 4 дүгээр сарын 13-ны Бямба гарагийн 10.00 цагт МУИС-ийн хичээлийн I-р байрны 3 давхрын 301 тоотод боллоо. Өдөрлөгт нийт 130 гаруй оюутан оролцсон ба тэнхимийн мэдээлэл агуулсан тараах материалыг бэлтгэж тараасан.

**2019 оны 4-р сарын 16**

### **Лазерын Судалгааны Төв байгуулах тухай**

Тус тэнхимийн Лазерын Судалгааны лабораторийг ШУС-ийн харьяа Лазерын Судалгааны Төв болгох асуудлыг тэнхимийн хурлаар авч хэлэлцэн, хамт олны 100% -ийн саналаар дэмжсэн. Улмаар МУИС-ийн захирлын 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Б/174 тоот тушаалаар МУИС-ийн стратеги төлөвлөгөөний зорилгод нийцүүлэн ШУС-ийн БУС-ийн ФТ-ийн Лазерын Судалгааны лабораторийг ШУС-ийн Лазерын Судалгааны Төв болгон 2019-04-15-ны өдрөөс өөрчлөн байгуулсан.

**2019 оны 4-р сарын 22**

### **Багш боловсролын оюутны эрдэм шинжилгээний хурал 2019**

МУИС-ийн Багш мэргэжлийн оюутнуудын дунд зохион байгуулагддаг “Багш боловсролын оюутны эрдэм шинжилгээний хурал”-д Физикийн Багш мэргэжлийн 2-р ангийн Н.Чанцалдулам, О.Мөнхбаясгалан гишүүдтэй баг нь тэргүүн байр, эзэлсэн. Физикийн Багш мэргэжлийн 3-р ангийн Б.Уянга, С.Даринчулуун гишүүдтэй баг нь гутгаар байр эзэлсэн.



2019 оны 4-р сарын 22-26

### УЛСЫН ФИЗИКИЙН 32 ДУГААР ОЛИМПИАД

"Оюуны дэвшилд хамтдаа" уриан дор Улсын физикийн 32 дугаар олимпиадыг 4-р сарын 22-26-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн төв Улсын тэргүүний Нэгдүгээр сургууль дээр зохион байгуулагдлаа. Уг олимпиадад 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан багш, сурагчид 9-р анги, 12-р анги, багш гэсэн 3 төрлөөр өрсөлдөх бөгөөд Өмнөговь аймагт болж буй улсын чанартай анхны удаагийн олимпиад юм. Олимпиадад ОХУ-аас багш, сурагчид оролцож буйгаараа онцлог аж. Олимпиадыг угтаж Улсын физикийн олимпиадын хороотой хамтран 5 удаагийн модуль сургалтыг орон нутагт болон Улаанбаатарт хийсний зэрэгцээ олимпиадын тугийг сургуулиудаар аялуулж физикийн туршилт, уралдаан тэмцээнийг зохион байгуулжээ.



2019 оны 4-р сарын 25

### “ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” ОЛОН УЛСЫН РОБОТЫН ТЭМЦЭЭН

“Буян-Ухаа” спорт цогцолборт Ази номхон далайн бүсийн орнуудын өргөн нэвтрүүлгийн холбоо, МҮОНРТ жил бүр хамтран зохион байгуулдаг Үндэсний роботын аварга шалгаруулах 18 дахь удаагийн тэмцээн амжилттай болж өнгөрлөө. Тус тэмцээнд 11 сургуулийн нийт 16 баг өөрсдийн бүтээсэн гар удирдлагат болон дөрвөн хөлтэй автомат роботоороо өрсөлдсөн. Түрүүлэх нь чухал бус оролцох нь чухал гэдэг зарчмын дагуу энэ жилийн “Робокон-2019” Үндэсний аварга шалгаруулах тэмцээнд инженер, техникийн боловсон хүчин бэлтгэдэг олон сургууль хамрагдаж, хүсэл тэмүүлэл зорилго дүүрэн зуун,



зуун шилдэг залуус мэдлэг туршлагаа солилцсон, үр өгөөж дүүрэн сайхан тэмцээн болж өнгөрлөө.



МУИС, Шинжлэх ухааны сургуулийн Физикийн тэнхимээс Монгол робот баг оролцсон.

**2019 оны 4-р сарын 29**

### **Бакалавр, магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурал**

Бакалавр, магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурал амжилттай болж өндөрлөлөө. Хуралд бакалаврын түвшний нийт 4 оюутан, магистрын түвшний нийт 6 оюутан оролцож илтгэл хэлэлцүүлэв.



Бакалаврын түвшинд:

I байранд 2-р түвшний оюутан Н.Чанцалдулам

II байранд 3-р түвшний оюутан О.Намуундарь, Э.Эрболд нар,

Магистрантын түвшинд:

I байранд магистрант З.Гарьд

II байранд магистрант Л.Эрдэнэбулган нар тус тус шалгарав.

**2019 оны 5-р сарын 2**


Д-р Д.Эрдэнэбаатар Eagle 22 нэвтрүүлэгт урилгаар оролцож МУИС-ийн физикийн тэнхим дээрх Сансар судлалын хөтөлбөрийн талаар болон хиймэл дагуулын төслүүд, түүний үр өгөөжийн талаар ярилцав.



2019 оны 5-р сарын 5-13

### Азийн физикийн 20-р олимпиад

Тус олимпиад нь Австрали улсын Аделаид хотод амжилттай болж өнгөрлөө. Энэхүү олимпиадад Азийн 20 гаруй орны 200 орчим хүүхэд оролцсон бөгөөд МУИС-ийн физикийн тэнхимийн ахлах багш доктор Г. Мөнхбаяр болон М. Отгонбаатар нар ахлах сургуулийн 8 сурагчийн хамт Монгол улсаа төлөөлөн амжилттай оролцлоо. Тус олимпиадад ерөнхий боловсролын 1-р сургуулийн 11-р ангийн сурагч Б. Цолмон шагналт байранд шалгарсан.



2019 оны 5-р сарын 8

### Инновацийн үзэсгэлэн 2019

Монголын анхны сансарт хөөрсөн бүтээл "Мазаалай хиймэл дагуул" - "Инновацийн Шилдэг Бүтээл" -ээр шалгарлаа. Хиймэл дагуул бүтээгч залуус өөрсдөө анхны төслийг олон нийтэд дахин танилцуулсан. Шүүгчдийн 99%-ийн саналаар шилдгээр шалгарсан 2 өдрийн үзэсгэлэнд маш олон хүмүүс ирж сонирхож, макетийг үзээд "ийм жижиг" зүйл юм уу гэж гайхах жишээтэй МУИС-ийн шилдэгүүдээрээ үнэхээр бахархаж байна.





**2019 оны 5-р сарын 11-12**

Р.Цолмон багш Дорнод их сургуульд сүүлийн 100 жилийн шинжлэх ухааны ололтууд, орчин үеийн сансар судлал, одон орны талаар мэдээлэл өгч, Галилейн дурантай ажиллах, Stellarium software дээр ажиллаж сурах, астрономийн хичээлийн ADA program-тай танилцах сургалтуудыг ЕБС-ийн физикийн багш нарт зохион байгууллаа.



**2019 оны 5-р сарын 16**

### **Их, дээд сургуулиудын оюутны физикийн III олимпиад**

Монгол улсын их, дээд сургуулиудын дунд уламжлал болгон зохиогддог ОЮУТНЫ ФИЗИКИЙН УЛСЫН III ОЛИМПИАД 2019 оны 05-р сарын 25-наас 26-ны өдрүүдэд МУИС дээр амжилттай зохион байгуулагдлаа. Хоёр даалгавартай явагдсан тус олимпиадад МУИС, ШУТИС, МГТИС, ШМТДС-ийн нийт 30 оюутан өрсөлдсөн.



1-р байр: Б.Магнайтүвшин ( UNIST )

2-р байр: Н.Чанцалдулам (МУИС ШУС), Д.Даваажаргал (Шинэ Монгол)

3-р байр: А.Сугармаа (Шинэ Монгол), Э.Түвшинзаяа (ШУТИС), О.Мөнхгэрэл (МГТИС)

Шагналт байр: Б.Төгөлдөр (МГТИС), Э.Мандахмаа (Шинэ Монгол), М.Анужин (МГТИС), А.Батбаяр (МГТИС)

Уран бодолт: Н.Энххүслэн нар тус тус шалгарлаа.

**2019 оны 5-р сарын 20**

2019 оны 05 сарын 20-оос 07 сарын 05-ныг хүртэл Олон улсын физикийн 50-р олимпиадад Монголын багийг ахлан оролцохоор Д-р. Г.Мөнхбаяр багш олимпиадын бэлтгэлээ хийж байна.

**2019 оны 5-р сарын 21**

### **Үндсээрээ сайжирсан Хэмжлийн нэгжийн олон улсын SI систем**

Дэлхийн Хэмжил Зүйн өдөрт зориулан Стандарт Хэмжил Зүйн газар болон Физикийн Нийгэмлэг хамтран “Үндсээрээ сайжирсан Хэмжлийн нэгжийн олон улсын систем” сэдэвт семинар зохион байгуулсан. Олон улсын SI системийн хэмжлийн нэгжийн зарим тодорхойлолтууд шинээр батлагдсан бөгөөд үүнийг 2019 оны 05-р сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөх болсонтой холбоотойгоор тус семинарыг зохион байгууллаа. Үүнд МУИС-ийн

ФТ, ШУТИС-ийн ФТ, МУБИС-ийн ФТ, ФТХ-гийн болон Стандарт Хэмжил Зүйн газрын хамт олон оролцсон.



**2019 оны 5-р сарын 23**

Хөдөө аж ахуйн их сургуультай хамтарсан “Ухаалаг газар тариалан” төслийн хүрээнд ХААИС-ын орчин, лабораториудтай танилцах уулзалт зохион багуулж тэнхимийн багш, лаборантуудтай оролцов.

**2019 оны 6-р сарын 4**

### **Нано хиймэл дагуул ба шинэ боломж**

МУИС-ийн захирлын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/245 дугаартай тушаалын дагуу, “Мазаалай” хиймэл дагуул сансарт хөөрсний хоёр жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн ШУС-ийн Нано хиймэл дагуул хөгжүүлэх лаборатори, МУИС-ийн Инноваци, Технологи дамжуулах төв хамтран “Нано Хиймэл Дагуул ба Шинэ боломж” бизнес уулзалт, арга хэмжээг 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Уулзалтын гол зорилго нь Мазаалай хиймэл дагуулын төслийн үр дүнг тайлагнаж, дотоодын нөөц бололцоонд тулгуурласан хөөргөхөөр төлөвлөж буй дараагийн хиймэл дагуул болох Тэмүүлэл төслийг танилцуулж, цаашид хиймэл дагуулыг хөгжүүлэх, хамтран ажиллах боломж, бизнесийн саналуудыг хэлэлцэх зорилготой юм.

“Тэмүүлэл” төсөл нь Шинжлэх ухааны судалгаа, технологийн туршилтыг сансарт хийх боломжтой кубсат ангиллын хиймэл дагуул бөгөөд Сансрын технологийг эзэмших, өндөр технологийг дотооддоо бүтээх, энэ салбарын боловсон хүчнийг бэлтгэх, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зорилготой төсөл юм. Уг төсөл нь гурван жилийн хугацаатай бөгөөд хиймэл дагуулын хөгжүүлэлт, угсралт, туршилт нь 2 жилийн хугацаанд, харин сансарт хөөрсний дараа нэг жил газраас удирдан ажиллах юм.





**2019 оны 6-р сарын 8**

### **Физик Боловсролын хөтөлбөр Ирээдүй" сэдэвт семинар**

Сэдэв: Физикийн түүх, уламжлал, олон улсын чиг хандлага, Технологийн хөгжил ба боловсролын ирээдүй, Одоогийн хөтөлбөр, давуу сул талууд, шинэчлэх боломж, Физикийн багшийн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, Физик инженерчлэл, хэрэглээ, хамтарсан хөтөлбөрийн талаар

**2019 оны 6-р сарын 10-15**

### **Одон орон олон улсын зуны сургалт, хурал**

Астрономи физик, байгалийн ухааны багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх олон улсын сургалт семинар зохион байгуулагдлаа. Сургалтанд 10-аад орны эрдэмтэн багш, МУИС-ийн болон 21 аймаг орон нутгийн 60-аад багш нар оролцон хичээл заах туршлага солилцоно. Зохион байгуулагч: МУИС-ийн Физикийн тэнхим

**2019 оны 7-р сарын 3-5**

### **Geant4-DNA олон улсын сургалт семинар**

Geant4-DNA олон улсын лекц-дадлага хосолсон сургалт семинар болж байна. АНУ-ын Станфордын Их сургууль, Франц дахь ЕХ-ны Geant-DNA төв, Geant4-DNA төв, ОУ-ын ЦШНИ, Японы КЕК төв, Австралийн анагаахуйн Волонгонг Их сургуулиас уригдан ирсэн эрдэмтэд, судлаачид лекц уншиж, тооцоо-дүрслэлт туршилт бүхий дадлага явууллаа.

ХӨСҮТ, Шастины эмнэлэг, Цөмийн энергийн комисс, ШУА-ийн Физик технологийн хүрээлэн, МУИС, АУШУҮС, судалгааны төвийн судлаач, багш, эмч, мэргэжилтэн нар оролцлоо. Цацрагийн үйлчлэлээр "алтны нанобөөмд" үрждэг хоёрдагч электроны урсгалаар хорт хавдрыг оношлох, эмчлэх, эд чиглэсэн тооцоо-дүрслэлт туршилтыг оролцогсод өөрснөө үйлдсэн нь онц сонирхолтой болов. Европын холбоон дахь

ОУ-ын Geant4/Geant4-DNA төв 80 мянга орчим долларын суурь програмуудыг үнэгүй олгож, эдгээр ОУ-ын байгууллагуудтай байнгын зөвлөгөөтэй хамтарч ажилласны дагуу МУИС-ШУС-д цогц лаборатори байгуулсан юм. Уг лабораторыг ОУ-ын төвшний судалгаа-сургалтад төвхнүүлснийг баталгаажуулах зорилгоор дээрх байгууллагуудаас мэргэжилтэнгүүд ирж хэд хэдэн лекц уншиж, дадлага хийлгэсэн.





## **Тэнхимийн семинар**

**2018 оны 10-р сарын 17**

МУИС, 1-р байр, 108тоот, 2018 оны 10 сарын 24 13:00 цаг  
Илтгэгч: Багш М. Батпүрэв  
Сэдэв: Кальцийн карбонатыг синтезлэх болон судлах

**2018 оны 10-р сарын 24**

МУИС, 1-р байр, 108тоот, 2018 оны 10 сарын 24 13:00 цаг  
Илтгэгч: Ахлах багш Ш.Мөнхжаргал  
Сэдэв: Кальцитийг дулааны аргаар боловсруулах явцад үүсэх нано бүтэцийн судалгаа

**2018 оны 11-р сарын 14**

МУИС, 1-р байр, 108тоот, 2018 оны 11 сарын 14 13:00 цаг  
Илтгэгч: Проф Л.Энхтөр багш  
Сэдэв: Кристаллын уян харимхай ба хүчний тогтмолыг тооцоолох

**2019 оны 2-р сарын 22**

МУИС, 1-р байр, 108тоот, 2019 оны 2 сарын 22, 14:30 цаг  
Илтгэгч: Проф Н.Цогбадрах багш  
Сэдэв: Хатуу бие, нанохэмжээсийн тооцоололт физик

**2019 оны 5-р сарын 31**

МУИС, 1-р байр, 108тоот, 2019 оны 2 сарын 22, 14:30 цаг  
Илтгэгч: Проф Ж.Даваасамбуу

Сэдэв: Кристалл дахь фазын шилжилтийг хугацаагаар ялгах синхротрон цацрагийн болон нейтроны сарнилын аргаар судалсан нь

## Физикийн их семинар

**2018 оны 10-р сарын 31**

МУИС-ийн хичээлийн I байр Дугуй заал 2018 оны 10 дугаар сар 31, 15цагт

Илтгэгч: Б.Отгонгэрэл (ШУА, ФТХ)

Сэдэв: Characteristics of particles produced in  $\pi$ -C interactions at 40 GeV/c as a function of cumulative number ( $n_c$ ) and phase transition

Зохион байгуулагч: МУИС-ийн Физикийн тэнхим

**2018 оны 11-р сарын 21**

МУИС, 1-р байр, Дугуй заал 2018 оны 11 сарын 21 13:00 цаг

Илтгэгч: Н.Тэгшбаяр /докторант, удирдагч: проф. Х.Цоохүү, проф. О.Болормаа/

Сэдэв: Монгол орны ундны усны ураны судалгаа

Зохион байгуулагч: МУИС-ийн Физикийн тэнхим

**2018 оны 12-р сарын 19**

МУИС, 1-р байр, Дугуй заал 2018 оны 12 сарын 19 15:00 цаг

Илтгэгч: Т.Төртогтох, PhD /ШУС-ФТ/

Сэдэв: Хиймэл дагуулын хөгжлийн хандлага, тулгамдаж буй асуудлын физик үндэслэл

Зохион байгуулагч: МУИС-ийн Физикийн тэнхим

**2019 оны 1-р сарын 30**

МУИС, 1-р байр, 301 тоот 14:00 цаг

Илтгэгч: Физикийн тэнхимийн Зөвлөх проф. О.Лхагва, Т.Тогтохтөр, Т.Лхагважав

Сэдэв: Алтны нано бөөмийн эрчимтэй судалгаа ба хавдрын эмчилгээний олон шинэлэг арга



**2019 оны 5-р сарын 16**

Илтгэгч: ШУТИС, ХШУС-ийн Физикийн тэнхимийн ахлах багш Г.Зоригт

Сэдэв: Цэнэгт бөөм-атомын мөргөлдөөний онолын судалгаа

Удирдагч багш : Доктор профессор Л.Хэнмэдэх

Зөвлөх багш: ШУ-ны доктор, профессор О.Лхагва

Доктор, Профессор Ш.Чадраабал

